



ДУНДГОВЬ АЙМАГ
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 04 өдөр

Дугаар А/95

Мандалговь

Хээлтүүлэгч малыг ээмэгжүүлэлт,
бүртгэлжүүлэлтэнд хамруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "а", Малын генетик нөөцийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.2 дахь заалт, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд, Дундговь аймгийн Засаг дарга нарын 2020 онд хамтран ажиллах гэрээг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Наран, Тэвш, Далай, Үйзэн багийн хээлтүүлэгч хуц, ухна, бухыг ээмэгжүүлж, дахин давтагдашгүй хувийн дугаараар тэмдэглэж, бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Х.Дашням (Хөдөө аж ахуйн тасгийн мал зүйч)

Гишүүд: Н.Баярсайхан (Наран багийн засаг дарга)

Ш.Батбаатар (Тэвш багийн засаг дарга)

Ж.Зоригтбаатар (Далай багийн засаг дарга)

Т.Батжаргал (Үйзэн багийн засаг дарга)

Б.Батбаяр (Хөдөө аж ахуйн тасгийн жолооч)

2. Ээмэгжүүлэлт бүртгэлжүүлэлтийн ажлыг 2020 оны 5 дүгээр сарын 04-ний өдрөөс эхлэн зохион байгуулж үр дүнг тайлагнахыг ажлын хэсгийн ахлагч Хөдөө аж ахуйн тасгийн мал зүйч (Х.Дашням)-д үүрэг болгосугай.

3. Ээмэгжүүлж, бүртгэлжүүлэх ажлын бэлтгэл ажлыг хангаж, малчдад мэдээлэл өгөх, бэлэн байдлыг хангуулах ажлыг үр дүнтэйгээр зохион байгуулж ажиллахыг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Р.МӨНХТОГТОХ

D:/document /Zasag darga/ A.Zahiramj .doc 05.04

482010248